АЖЛЫН ДААЛГАВАР

Төсөл, арга хэмжээний нэр: “Тусгай хамгаалалттай газар нутгийн зарим хамгаалалтын захиргаанд алсын удирдлагатай камер болон нарны эрчим хүчний системээр хангах”

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Төслийн зорилго	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Германы Сэргээн босголт, Зээлийн банкаар дамжуулан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II&III үе шатыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран 2020 оны 03 дугаар сараас хэрэгжүүлж байна. Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд чухал ач холбогдол бүхий газруудын үр ашигт байдал, тогтвортой менежментийг сайжруулах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны шинэ эх үүсвэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ. Улсын хэмжээнд ТХГН-ийн хамгаалалтын захиргааны эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний технологи нэвтрүүлэх, байгаль орчны эргүүл, хяналт шалгалтыг ахисан түвшинд хийх, онцгой газруудад тавих хяналтын ажилд алсын зайн хяналтын камер ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилготой**.**
2.	Ажлын үндэслэл	ТХГН-ийн Хамгаалалтын захиргаадын нарны эрчим хүчний систем (цаашид НЭХС гэх)-ийн болон алсын удирдлагатай камер (цаашид *АЗХК гэх*-Алсын Зайн Хяналтын Камер*)*-ын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг 2024 онд хийлгэсэн ба нийт 18 ТХГН-н хамгаалалтын захиргааны барилгын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон НЭХС суурилуулах шаардлагатай төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй ба одоо байгаа цахилгааны төхөөрөмж нь хүчин чадал хүрэхгүй, төвлөрсөн сүлжээнд холбогдсон ч цахилгаанаар халдаг бөгөөд цахилгааны төлбөр нь төсөвт ачаалал өгдөг зэрэгээр эрэмблэн Говийн их ДЦГ “Б” хэсгийн Тахь сэргээн нутагшуулах, судалгааны төвд 10кВт, Хомын талын БЦГ-н хамгаалалтын захиргааны барилгад 20кВт, Хар Ус нуурын ТХГН-ийн хамгаалалтын захиргааны барилгад 35кВт, Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгад 35кВт, Нөмрөгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилгад 15кВт, Нөмрөгийн ДЦГ-ын Тахь нутагшуулах төвд 20кВт, ГИДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргааны барилгад 20кВт байхаар сонгосон. (*НЭХС-ийн хэрэгцээ, шаардлагын судалгааг хавсаргав).*

		ТХГН-дад зэрлэг амьтан, ургамлын ажиглалт мониторинг болон хулгайн ан, хууль бус уул уурхайн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх хяналтын ажилд АЗХК-ыг ашиглах шаардлагатай 49 цэгийг тогтоосон. */АЗХК-ын хэрэгцээ шаардлагын судалгааг хавсаргав/.* ТХГН-ийн хамгийн чухалд тооцогдох цэгийг хамгаалалтын захиргаадтай зөвлөлдөж сонгосон 6 байршил дээр тус бүр нэг иж бүрдэл буюу нийт 6 иж бүрдэл АЗХК-уудыг нэг иж бүрдэл нэгдсэн сүлжээний дүрс бичлэгийн төхөөрөмж(main NVR)-ийн хамт нийлүүлж, суурилуулах ба ашиглалт туршилтын үр дүнг үнэлнэ. Төслийн 2 ба 3-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаадын оффисын цахилгааны хэрэглээг нарны эрчим хүчний системээр хангах, ТХГН-ын алслагдсан хэсэгт хуулийн зөрчил их гарах магадлалтай газруудад хяналтыг алсын зайн хяналтын камераар хийх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор, “ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаадыг алсын зайн хяналтын камер, нарны эрчим хүчний системээр хангах” ажлыг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан нь энэхүү худалдан авалтын ажлын үндэслэл болно.
3.	Хамрах хүрээ	НЭХС нь ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын оффисын болон тахь нутагшуулах төвүүдийн барилгыг цахилгаанаар хангах төхөөрөмж нийлүүлж угсрах, төвийн эрчим хүчний системд холбох ба өөрөө үйлдвэрлэсэн илүүдэл цахилгааныг төвийн эрчим хүчний сүлжээнд борлуулах зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах, гэрээ байгуулах зэрэг дагалт үйлчилгээг хамрах ба АЗХК нь алслагдсан цэгүүдэд хяналт, мониторинг хийх тоног төхөөрөмжийг нийлүүлж угсрах, харилцаа холбооны болон бусад холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах, баталгаажуулах зэрэг дагалдах үйлчилгээ үзүүлэх ажлыг хамарч 2 өөр мэргэжлийн байгууллага/багийн гүйцэтгэх ажил бөгөөд тэдгээрийг угсарч суурилуулах газруудын газар зүйн байршил өөр өөр учраас энэхүү тендерийг НЭХС ба АЗХК гэсэн төрлөөр ангилж 2 багц болгон зарлана. Иймд тендерийн хүрээнд дараах иж бүрдэл бараануудыг тодорхойлогдсон газруудад хүргэж тэдгээрийг угсарч суурилуулан хүлээлгэж өгөх дагалдах үйлчилгээ хийгдэнэ. Үүнд: 1. Дараах 6 хамгаалалтын захиргааны хариуцдаг 7 байршилд Нарны Эрчим Хүчний Системийн иж бүрдэл барааг тухайн мэргэжлийн туршлагатай хуулийн этгээд нийлүүлж, суурилуулах ажлын схем зураг боловсруулан угсарч, туршин ажиллуулж хүлээлгэн өгнө. Үүнд: 1. ГИДЦГ-ын “Б” хэсгийн Тахь Сэргээн Нутагшуулах, Судалгааны Төвд 10 кВт-ийн чадалтай, бие даасан ажиллагаатай НЭХС,

		2. Хомын талын БЦГ-н хамгаалалтын захиргааны оффисын барилгад 20 кВт-ын, бие даасан ажиллагаатай НЭХС, 3. Хар Ус нуурын ТХГН-ийн хамгаалалтын захиргааны оффисын барилгад 35 кВт -ын хосолмол ажиллагаатай НЭХС, 4. Говийн их ДЦГ А хэсгийн хамгаалалтын захиргааны оффисын барилгад 20 кВт, хосолмол ажиллагаатай НЭХС, 5. Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргааны оффисын барилгад 35 кВт, хосолмол ажиллагаатай НЭХС, 6. Нөмрөгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны оффисын барилгад 15 кВт, хосолмол ажиллагаатай НЭХС, 7. Нөмрөгийн ДЦГ-ын Тахь нутагшуулах төвд 20 кВт, бие даасан ажиллагаатай НЭХС-ийг тус тус нийлүүлж суурилуулах зураг схем боловсруулан, угсарч суурилуулан хүлээлгэн өгнө. 2. Дараах 5 хамгаалалтын захиргаадын хариуцдаг 6 байршилд тус бүр нэг буюу нийт 6 иж бүрдэл АЗХК барааг энэ чиглэлээр туршлагатай аж ахуйн нэгж нийлүүлж тээвэрлэн хүргэж, угсарч суурилуулан сүлжээнд холбон ажиллуулж хүлээлгэн өгнө. Мөн БОУАӨЯ-ны цахим серверийн өрөөнд АЗХК-уудын нэгдсэн **с**үлжээний дүрс бичлэг(main NVR)-ийн нэг иж бүрдэл төхөөрөмжийг нийлүүлж, угсарч суурилуулан бүрэн ажиллагаанд оруулан хүлээлгэж өгнө. /Барааны хуваарилалт хавсралт-3/ Үүнд: 1. Говийн Их ДЦГ-ын А хэсгийн “Баруун тоорой”, 2. Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн “Тахийн Ус”, 3. Их Богдын БЦГ-ын “Хэлтгий булаг”, 4. Хар Ус Нуур орчмын БЦГ-ын “Таван толгой”, 5. Нөмрөгийн ДЦГ-ын “Сүмийн хоолой”, 6. Нөмрөгийн ДЦГ-ын “Дэгээгийн гүүр”, 7. БОУАӨЯ -ны серверийн өрөө зэрэг болно.
4.	Хийх ажлын иж бүрдэл	1-р багц төхөөрөмж: НЭХС – 7 иж бүрдэл, Үүнд: 1. 10 кВт-ын хүчин чадалтай (offgrid) 1 иж бүрдэл; 2. 15 кВт-ын хүчин чадалтай (hybrid) 1 иж бүрдэл; 3. 20 кВт-ын хүчин чадалтай (offgrid) 2 иж бүрдэл; 4. 20 кВт-ын хүчин чадалтай (hybrid) 1 иж бүрдэл; 5. 35 кВт-ын хүчин чадалтай (hybrid) 2 иж бүрдэл; 2-р багц төхөөрөмж: АЗХК-ын системийн 7 иж бүрдэл, Үүнд: 1. АЗХК (байнгын) 5 иж бүрдэл; 2. АЗХК (хөдөлгөөнт) 1 иж бүрдэл; 3. Нэгдсэн сүлжээний дүрс бичлэгийн төхөөрөмж 1 иж бүрдэл; Нийт 14 иж бүрдэл барааг түүний дагалдах үйлчилгээний хамт ажлын даалгаврын хавсралтуудад заасан тоо ширхэг, техникийн

		үзүүлэлт, тодорхойлолтын дагуу нийлүүлэхдээ барааг Улаанбаатар хотод оруулж ирсний дараа Захиалагчид танилцуулж, хуваарилсан газруудад тээвэрлэн хүргэж, угсарч суурилуулан, бүрэн ажиллагаанд оруулж ТХГН-ийн хамгаалалтын захиргаадад болон БОУАӨЯ-д “бараа хүлээлцсэн акт” үйлдэж хүлээлгэн өгнө.
5.	Хүлээн авах бараа материал, тайлан	**1. НЭХС нийлүүлэх ажлын хүрээнд:** - Гэрээнд болон ажлын даалгаврын нэгдүгээр хавсралтад заасан тоо, чанар, техникийн үзүүлэлт бүхий НЭХС-ийн 7 иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, - Заасан газруудад НЭХС-ийн иж бүрдлийг угсран суурилуулах ажлын зураг, схемийг боловсруулан холбогдох байгууллагаар баталгаажуулан угсралтын ажилд ашиглах, - Төвийн эрчим хүчний системд холбогдон ажиллах хосолмол (habrid) ажиллагаатай НЭХС-ийг төвийн эрчим хүчний системд холбох, үйлдвэрлэсэн илүүдэл эрчим хүчийг төвийн эрчим хүчний системд буцаан нийлүүлж борлуулахтай холбоотой зөвшөөрлийг гэрээний хугацаанд холбогдох эрчим хүчний байгууллагаас авах, эрчим хүчний байгууллага болон хамгаалалтын захиргааны хооронд гэрээ байгуулж хүлээлгэн өгөх, - Барааг Улаанбаатар хотод импортлон оруулж ирсний дараа БОУАӨЯ-аас томилогдсон ажлын хэсэгт болон төслийн зөвлөх багаас томилогдсон ажилтнаар шалгуулж угсрах зөвшөөрөл авна. Үүний дараа дээрх иж бүрдэл барааг нийлүүлэх, угсарч суурилуулах бүрэн ажиллагаанд оруулах ажлыг гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлж Ажлын даалгаврын гуравдугаар хавсралтад заасан ТХГН-ийн Хамгаалалтын захиргаадад бараа хүлээлцсэн акт үйлдэж хүлээлгэн өгнө. **2.АЗХК нийлүүлэх ажлын хүрээнд:** - Энэхүү барааг нийлүүлэх ажлын гэрээнд болон ажлын даалгаврын хоёрдугаар хавсралтад заасан тоо, чанар, техникийн үзүүлэлт бүхий 7 иж бүрдэл тоног төхөөрөмжүүдийг захиалагчид нийлүүлэх, - Барааг Улаанбаатар хотод импортлон оруулж ирсний дараа БОУАӨЯ-аас томилогдсон ажлын хэсэгт болон төслийн зөвлөх багаас томилсон IT инженерээр шалгуулах - АЗХК-уудыг угсран суурилуулах ажлын зураг, схемийг боловсруулан холбогдох хамгаалалтын захиргаа болон захиалагчтай зөвшилцөн протокол үйлдэн баталгаажуулж ашиглах, - АЗХК-ыг ашиглах үед сүлжээнд холбогдох шаардлага, холбогдох зөвшөөрлийг авах, аянга цахилгааны эрсдэлээс сэргийлэх, геологийн тандалт, судалгаа хийж, техникийн болон эрх зүйн нөхцөлүүдийг бүрдүүлж баталгаажуулах, - АЗХК-ын дүрс бичлэг, мэдээллүүдийг дамжуулах, хадгалах, ашиглахад шаардлагатай Нэгдсэн Сүлжээний Дүрс Бичлэгийн

		төхөөрөмж(main NVR) нэг иж бүрдлийг БОУАӨЯ-ны серверийн өрөөнд зориулалтын зогсуур(рак)-д байрлуулан угсарч суурилуулан бүрэн ажиллагаанд оруулах ба ТХГНБГ-ын хариуцсан мэргэжилтэнд АЗХК-ын нэгдсэн сүлжээний дүрс бичлэгийн төхөөрөмжийн иж бүрдэлд дагалдах камерын хяналтын компьютер, АЗХК-ын удирдлага(Joystick) зэрэг тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгөх ба шаардлагатай гарын авлага, видео заавар, сургалт зөвлөгөөг өгөх, - Дээрх 7 иж бүрдэл барааг ажлын даалгаврын гуравдугаар хавсралтад заасан Хамгаалалтын захиргаадад болон БОУАӨЯ-д гэрээнд заасан хугацаанд тээвэрлэн хүргэж, угсарч суурилуулан АЗХК-ын системийг бүрэн ажиллагаанд оруулсны дараа “бараа хүлээлцсэн акт” үйлдэж захиалагчид бүрэн хүлээлгэн өгнө. **3. Тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, засвар үйлчилгээний хүрээнд:** - Нийлүүлж угсарч суурилуулсан бүх тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, засвар үйлчилгээ, ХАБЭА-н зааварчилгаа зэрэг шаардлагатай мэдээлэл агуулсан богино хэмжээний сургалтыг барааг хүлээн авч буй байгууллагын мэргэжилтнүүд болон хамгаалалтын захиргааны ажилтнуудыг оролцуулан зохион байгуулах, - Тоног төхөөрөмжүүдийн гарын авлагыг Монгол хэл дээр бэлтгэж, бараа бүтээгдэхүүний хамт хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгнө. Сургалтад ашигласан мэдээ материал, хичээл, ppt слайд, фото зураг зэргийг тайлангийн хавсралт байдлаар хүлээлгэн өгөх, - Хүлээлгэн өгснөөс хойш 1-ээс доошгүй жилийн хугацаанд НЭХС, АЗХК-уудын иж бүрдэл тоног төхөөрөмжүүдэд чанарын баталгаа гаргаж, засвар үйлчилгээг хариуцах ба баталгаат хугацаанд шаардлага гарсан үед заавар, зөвлөгөөг БОУАӨЯ, Хамгаалалтын Захиргаадад биечлэн эсхүл зайнаас шуурхай үйлчилгээ үзүүлж байх, - Байгуулсан АЗХК-уудын цамхгийн бетон сууринд 1 жилээс доошгүй хугацаатай баталгааг хамгаалалтын захиргаадад өгөх.
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 210 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. *Гэрээний нийт үргэлжлэх 210 хоногийн хугацаа нь Гэрээлэгч барааг Захиалагчид хүлээлгэн өгч, акт үйлдэж, Захиалагч гэрээний эцсийн төлбөрийг Гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн байхаар тооцсон хугацаа болно.*
7.	Хүрэх үр дүн	- НЭХС суурилуулсан хамгаалалтын захиргаадын оффисын цахилгаан эрчим хүчний хангамж сайжирч, төсөв НЭХС-ээр үйлдвэрлэсэн илүүдэл цахилгааныг төвийн сүлжээнд борлуулан орлого олж цахилгаан ашиглалтын урсгал зардлыг бууруулах, төсөв

		хэмнэх, ажиллагчдын ажлын бүтээмж дээшлэх боломжууд сайжирна. - АЗХК-тай болсноор төсөлд хамрагдсан ТХГН-ийн мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын байгаль орчны хяналт мониторингийн ажлыг ахисан шатанд хийх, цаг хугацаа, шатахуун, хүн хүч хэмнэх боломж бүрдэж мэдээ баримт цуглуулах, цаашдын ажил төлөвлөлтөд системтэй ашиглах чадавх сайжирна. - Байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах ажилд ахиц гарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
8.	Тендерт оролцогчид тавигдах ерөнхий шаардлага	8.1 Тендерт оролцогчид дараах ерөнхий шаардлага тавигдана. Үүнд: - Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлагыг хангасан байх, - Техникийн тодорхойлолтыг хангах - Холбоо харилцааны тухай болон Эрчим хүчний тухай Монгол Улсын хуулиуд, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, журам, дүрэм, шаардлагуудыг хангаж ажиллах, - БОЯБХУАӨДЗТ-ийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог баримтална (https://baccp.mn/project/detail_3). - Тендерийн баримт бичигт заасан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт, Зээлийн банк (*KfW*)-ны бусад нөхцөл, шаардлага. 8.2 НЭХС суурилуулах тендерт оролцогчид нь нийлүүлсэн төхөөрөмжүүдийн угсралтын ажлыг иж бүрэн хийж туршиж хүлээлгэн өгөх ба дараах шаардлага тавигдана. Үүнд: 8.2.1 Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: 8.2.1.1 Сүүлийн 2 жилд буюу 2023, 2024 оны нийлбэрээр багцын төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласныг нотлох. Үүнд: - Гүйцэтгэсэн 2-оос доошгүй гэрээ, гэрээний биелэлт дүгнэсэн акт ирүүлэх, - Нийлүүлсэн ижил төстэй бараа бүтээгдэхүүнийг угсарч суурилуулсан байдлыг фото зургаар хавсаргах, 8.2.2 Тусгай зөвшөөрөл: - Эрчим хүчний яамны ТЗ-1.1 зөвшөөрөл, 8.2.3 Санхүүгийн чадавхын хэмжээ:

- Борлуулалтын орлогын хэмжээ: 2023, 2024 оны борлуулалтын орлогын хэмжээ нь багцын төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх,

8.2.4 Хүний нөөц: Дараах үндсэн мэргэжилтнүүдтэй байна.

№	Албан тушаал	Боловсрол мэргэжлийн ур чадвар	тоо	Нийт ажлын туршлага	Үндсэн/ гэрээт
1	Цахилгааны ерөнхий инженер	Цахилгааны ерөнхий инженер зэрэгтэй байх	1	5-с дээш жил	Үндсэн ажилтан байх
2	Цахилгааны инженер	Цахилгааны инженер зэрэгтэй байх	1	3-с дээш жил	Үндсэн ажилтан байх
3	Цахилгаанчин	Цахилгаанчин	3	3-с дээш жил	1 нь үндсэн, 2 нь гэрээт ажилтан байж болно.
4	ХАБЭА-н ажилтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны гэрчилгээтэй байна	1	3-с дээш жил	Үндсэн ажилтан байх

8.2.5 Ажил гүйцэтгэхэд ашиглагдах дараах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх:

№	Төрөл	Хүчин чадал	Өмчлөл
1	Ачааны автомашин	4 тонн-с багагүй	Өөрийн эсхүл түрээсийн байж болно
2	Үйлчилгээний автомашин	1 хүртэл тонн даацтай бартаат замын машин	

8.3 АЗХК суурилуулах тендерт оролцогчид нь нийлүүлсэн төхөөрөмжүүдийн угсралтын ажлыг иж бүрэн хийж туршиж хүлээлгэн өгөх ба дараах шаардлага тавигдана. Үүнд:

8.3.1 Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага:

- Сүүлийн 2 жилд 2023, 2024 оны нийлбэрээр багцын төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.

8.3.2 Тусгай зөвшөөрөл:

- Харилцаа холбооны зохицуулах хорооны “Б” зөвшөөрөл.

8.3.3 Санхүүгийн чадавхын хэмжээ:

- Борлуулалтын орлогын хэмжээ: 2023, 2024 оны борлуулалтын орлогын хэмжээ нь багцын төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх.

8.3.4 Хүний нөөц: Дараах үндсэн мэргэжилтнүүдтэй байна.

№	Албан тушаал	Боловсрол мэргэжлийн ур чадвар	Тоо	Нийт ажлын туршлага	Үндсэн /гэрээт
1	IT инженер	Техник, программ хангамжийн инженер, мэдээлэл технологийн магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх	1	Видео тандалт, хяналтын камерын системийн иж бүрэн шийдлүүд гаргах чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх	Үндсэн ажилтан байх
2	Цахилгааны инженер	Цахилгааны инженер зэрэгтэй байх	1	3-с дээш жил ажилласан туршлагатай байх	Үндсэн ажилтан байх
3	IT-ийн мэргэжилтэн	Мэдээллийн технологийн чиглэлээр бакалаврааc дээш зэрэгтэй байх	2	Тухайн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх	Нэг нь үндсэн, Нэг нь гэрээт ажилтан байж болно.
4	ХАБЭА-н ажилтан	ХАБЭА-н ажилтны гэрчилгээтэй байх	1	3-с дээш жил ажилласан туршлагатай байх	Үндсэн ажилтан байх

8.3.5 Ажил гүйцэтгэхэд ашиглагдах дараах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх:

№	Төрөл	Хүчин чадал	Өмчлөл
1	Крантай ачааны автомашин	1 тонн-с багагүй	Өөрийн эсхүл түрээсийн байж болно
2	Үйлчилгээний автомашин	1 хүртэл тонн даацтай бартаат замын машин	

9.	Захиалагч байгууллага	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам.
10.	Санхүүжил-тийн эх үүсвэр	Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Сэргээн Босголт, Зээлийн банк (*KfW*)-аар дамжуулан БОУАӨЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” BMZ 201667054, 201868272 төсөл.
11.	Нийт санхүүжилт	1,434,637,890.00 (Нэг тэрбум дөрвөн зуун гучин дөрвөн сая зургаан зуун гучин долоон мянга найман зуун ерэн) төгрөг. Үүнээс: 1-р багц НЭХС-ийн 7 иж бүрдэлд: 893,472,000 төгрөг; 2-р багц АЗХК-ын 7 иж бүрдэлд: 541,165,890 төгрөг;
12.	Худалдан авах ажиллагаанд дагаж мөрдөх хууль, дүрэм, журам	- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Сэргээн Босголт Зээлийн банк (*KfW*)-ны “Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”; - ХБНГУ-ын Сэргээн Босголт Зээлийн банк (*KfW*)-ны БОНМБ-ийн шаардлага, стандартууд; - Санхүүжүүлэгчээр батлагдсан Бараа нийлүүлэх тендерийн баримт бичиг; - Захиалагчаар батлагдсан тендерийн баримт бичиг болон ажлын даалгавар;

“Тусгай хамгаалалттай газар нутгийн зарим хамгаалалтын захиргаанд алсын удирдлагатай камер болон нарны эрчим хүчний системээр хангах” тендерээр худалдан авах барааны Ажлын даалгаврын нэгдүгээр хавсралтаар НЭХС-барааны техникийн тодорхойлолтыг, Ажлын даалгаврын хоёрдугаар хавсралтаар АЗХК-ын иж бүрдэлд орох тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг, Ажлын даалгаврын гуравдугаар хавсралтаар барааны хуваарилалтыг тус тус батлав.

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------

АЖЛЫН ДААЛГАВРЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

“Тусгай хамгаалалттай газар нутгийн зарим хамгаалалтын захиргаанд алсын удирдлагатай камер болон нарны эрчим хүчний системээр хангах” тендерийн хүрээнд худалдан авах НЭХС-барааны техникийн тодорхойлолт

Хүснэгт 1.1 10кВт чадалтай НЭХС-н (бие даасан нэг иж бүрдэл) тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, жагсаалт:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Нарны хавтан	16	Нарны дэлгэц хавтан нийт чадал нь 10кВт нэг бүр нь 650Вт чадалтай, моно кристалл. Системийн хүчдэл 1500В, АҮК 24%-аас дээш байна. Мөндөрийн туршилт 23м/с хурдтай 25мм-ийн мөндөр тэсвэрлэх туршилт хийсэн гэрчилгээтэй байна. Нүүрнээсээ 5400Па даралт тэсвэрлэхүйц бат бөх байна. Хамгаалалтын зэрэглэл нь IP 68, Чадлын хүлцэл: 0...+3%, Нийцэх стандарт: IEC61730, Нарны дэлгэцийн суурь, батарейны суурь, холболтын хайрцаг, хуваарилах самбар, холбох хэрэгслүүд гэх мэт тоноглолууд дагалдсан байна. Ажиллах хугацаа: 25 жил Үйлдвэрийн баталгаа: 10 жил
2	Хайбрид инвертер, 10кВт, 230/400В	1	10кВт хүчин чадалтай 230/400В хүчдэл гаргах, гадна орчноос тусгаарлах IP65 байна. *Нарны дэлгэцийн оролт:* Оролтын дээд чадал: 13 кВт, Оролтын дээд хүчдэл: 1000 В, MPPT Хүчдэлийн хүрээ: 150-800 В, *Батарейны холболт:* Хүчдэлийн хүрээ: 160-700 В, Цэнэглэх/ цэнэг алдуулах гүйдэл: 37 А Хяналт: Батарей хяналтай байна (BMS). Цэнэглэлтийн горим: лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан батарей байна. *Инвертерийн гаргалгаа:* Нэрлэсэн чадал: 10кВт, Бүрэн чадал: 11 кВА, Хэлхээний гаргалтын гүйдэл: 14.5 А, Нэрлэсэн хүчдэл (V): 230/400, Фазын тоо: 3, Давтамж 50 Гц, Чадлын коэффицент 1 (-0.8–0.8) тохируулах боломжтой байна. Гүйдлийн THD (<3%) *Хамгаалалтууд:* DC урвуу холболтын хамгаалалттай, Хэт гүйдэл/хүчдэлийн хамгаалалттай, Богино холболтын хамгаалалттай,

			Гүйдлийн алдагдлын хамгаалалттай, Сүлжээний хяналттай байна. Хамгаалалтын зэрэглэл IP 65. *Ерөнхий мэдээлэл:* Хийц: трансформаторгүй, агаарын хөргөлттэй, орчны чийгшил 0-100%, Ажиллах хэм: -40°C... +60°C, Ажиллах өндөржилт (<2000м), Шуугианы үзүүлэлт (< 55 dB), Ачаалалгүй үеийн хэрэглээ (< 5 W), Мэдээлэл дамжуулалт, хяналт: LCD, LED, / WIFI / RS485/RS232/CAN, Вэб хяналтын систем Сүлжээний стандарт: IEC 61727, IEC 62116, CEI 0-21, EN 50549, NRS 097, RD 140, UNE 217002, OVE-Richtlinie R25, G99, VDE-AR-N 4105 Аюулгүй байдлын стандарт: IEC/EN 61000-6-1/2/3/4, IEC/EN 62109-1, IEC/EN 62109-2
3	Цэнэг хураагуур	1 ком	51.2V 100 Ач-ийн нэгж багтаамжтай 6 ширхэг, нийт 30.72 кВт.ц эрчим хүч хадгална. лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан. Ажиллах хэм: -0^0C - $+50^0$C, Нэгж батарейны хүчдэл: 51.2 В, Циклийн тоо: 6000, болон 15 жил Технологи: лити-ион (Lithium-ion) LFP, Стандарт: IEC62619, CE-EMC, UN 38.3
4	Цэнэг хураагуур суурь	1 ком	Цэнэг хураагуур суурилуулах зориулалттай.
5	Нарны хавтангийн холболтын суурийн төмөр деталиуд	1 ком	Бетонд суурилуулах Т хэлбэрийн ган төмөр хөл, урд болон ард босоо хөлийн гар төмөр, Хөндлөн болон эгнээнд зориулсан цайрдсан ган төмөр зориулалтын төмөр деталиуд, залгааны деталиуд гэх мэт байна. Булан төмөр нь 5см х 5см өргөнтэй х 0.3см зузаантай байна. Дэлгэцийн тооноос хамаарсан, задгай талбайд суурилуулахаар үйлдвэрт хийгдсэн байна.
6	PV кабелиуд	300м	Хар болон улаан өнгийн 4мм2 голчтой. Зэс голтой, өвөл хөлддөггүй.
7	DC кабель	60м	25мм2 голчтой, зэс утастай. Цэнэг хураагуураас инвертерт холбох
8	MC 4 коннектор	30ш	Нарны хавтангийн холболтод ашиглах
9	Газардуулга	1 ком	8ш зэс гадас, хооронд холбох 2см зузаантай полса
10	Аянга зайлуулагч	1 ком	2м өндөр шон, аянга зайлуулагч, 10м 6мм голчтой газардуулгын кабель, Аянга зайлуулагчийг газарт зоож суурилуулахдаа хөндлөнгийн хяналт хийх нэг мэргэжилтнийг (хамгаалалтын захиргаа эсвэл төслөөс) заавал байлцуулна.
11	Бетон суурь	1 ком	Салхины хурд 50м/с, цасны тогтох зузаан 20см байхад тогтвортой бетон суурийг 2м тутамд М250 маркын бетон зуурмагаар хийнэ.

			Ус, чийгнээс хамгаалж, хар замаск түрхнэ. Нарны хавтангийн суурилуулалтын зургийг боловсруулж захиалагчтай зөвшилцөнө.

Хүснэгт 1.2 15 кВт чадалтай НЭХС-н (хосолмол нэг иж бүрдэл) тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, жагсаалт:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Нарны хавтан	24	650Вт нэгж чадалтай, моно кристалл. Системийн хүчдэл 1500В, АҮК 24%-аас дээш, нийт 15кВт чадалтай байна. Мөндөрийн туршилт 23м/с хурдтай 25мм-ийн мөндөр тэсвэрлэх туршилт хийсэн байна. Нүүрнээсээ 5400Па даралт тэсвэрлэхүйц бат бөх байна. Хамгаалалтын зэрэглэл нь IP68, Чадлын хүлцэл: 0...+3%; Нийцэх стандарт: IEC61730 Нарны дэлгэцний суурь, батерейны суурь, холболтын хайрцаг, хуваарилах самбар, холбох хэрэгслүүд гэх мэт тоноглолууд дагалдсан байна. Ажиллах хугацаа: 25 жил Үйлдвэрийн баталгаа: 10 жил
2	Хайбрид инвертер, 15кВт, 230/400В (Хосолмол НЭХС-ийн хувьд төвийн эрчим хүчний сүлжээнээс цахилгаан авах, нийлүүлэх шаардлага хангасан байх)	1	15кВт хүчин чадалтай 230/400В хүчдэл харгах, DC урвуу холболтын хамгаалттай, гадна орчноос тусгаарлах IP66 байна. *Нарны дэлгэцний оролт:* Оролтын дээд чадал: 19.5 кВт Оролтын дээд хүчдэл: 1000В MPPT Хүчдэлийн хүрээ: 150-850 В *Батерейны холболт:* Хүчдэлийн хүрээ: 160-700 В Цэнэглэх/ цэнэг алдуулах гүйдэл: 37 А Хяналт: Батарей хяналтай байна (BMS). Цэнэглэлтийн горим: лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан батерей байна. *Инвертерийн гаргалгаа:* Нэрлэсэн чадал:15 кВт, Бүрэн чадал: 16.5 кВт, Хэлхээний гаргалтын гүйдэл 21.8 А, Нэрлэсэн хүчдэл (V): 230/400, Фазын тоо: 3, Давтамж 50 Гц,

			Чадлын коэффицент 1 (-0.8–0.8) тохируулах боломжтой байна. Гүйдлийн THD (<3%) *Хамгаалалтууд:* DC урвуу холболтын хамгаалалттай, Хэт гүйдэл/хүчдэлийн хамгаалалттай, Богино холболтын хамгаалалттай, Гүйдлийн алдагдлын хамгаалалттай, Сүлжээний хяналттай байна. Хамгаалалтын зэрэглэл IP 66 *Ерөнхий мэдээлэл:* Хийц: трансформаторгүй, агаарын хөргөлттэй, орчны чийгшил 0-100%, Ажиллах хэм: -40°C ... +60°C, Ажиллах өндөржилт (<4000м), Шуугианы үзүүлэлт (< 40 dB), Ачаалалгүй үеийн хэрэглээ (< 5 W), Мэдээлэл дамжуулалт, хяналт: LCD, LED, / WIFI / RS485/RS232/CAN, Вэб хяналтын систем Сүлжээний стандарт: IEC 61727, IEC 62116, CEI 0-21, EN 50549, NRS 097, RD 140, UNE 217002, OVE-Richtlinie R25, G99, VDE-AR-N 4105 Аюулгүй байдлын стандарт: IEC/EN 61000-6-1/2/3/4, IEC/EN 62109-1, IEC/EN 62109-2
3	Цэнэг хураагуур	1 ком	51.2V 100 Ац-ийн нэгж багтаамжтай 6 ширхэг, нийт 30.72 кВт.ц эрчим хүч хадгална. лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан. Ажиллах хэм: -0^0C - $+50^0$C, Нэгж батерейны хүчдэл: 51.2 В, Циклийн тоо: 6000, болон 15 жил Технологи: лити-ион (Lithium-ion) LFP, Стандарт: IEC62619, CE-EMC, UN 38.3
4	Цэнэг хураагуурын суурь	1 ком	Цэнэг хураагуур суурилуулах зориулалттай.
5	Нарны хавтангийн холболтын суурийн төмөр деталиуд	1 ком	Бетонд суурилуулах Т хэлбэрийн ган төмөр хөл, урд болон ард босоо хөлний гар төмөр, Хөндлөн болон эгнээнд зориулсан ган төмөр зориулалтын төмөр деталиуд, залгааны деталиуд гэх мэт байна. Булан төмөр нь 5см х 5см өргөнтэй х 0.3см зузаантай байна.

			Дэлгэцийн тооноос хамаарсан, задгай талбайд суурилуулахаар үйлдвэрт хийгдсэн байна.
6	PV кабелиуд	300м	Хар болон улаан өнгийн 4мм2 голчтой. Зэс голтой, өвөл хөлддөггүй.
7	DC кабель	60м	25мм2 голчтой, зэс утастай. Цэнэг хураагуураас инвертерт холбох
8	MC 4 коннектор	30ш	Нарны хавтангийн холболтод ашиглах
9	Газардуулга	1 ком	8ш зэс гадас, хооронд холбох 2см зузаантай полса
10	Аянга зайлуулагч	1 ком	2м өндөр шон, аянга зайлуулагч, 10м 6мм голчтой газардуулгын кабель Аянга зайлуулагчийг газарт зоож суурилуулахдаа хөндлөнгийн хяналт хийх нэг мэргэжилтнийг (хамгаалалтын захиргаа эсвэл төслөөс) заавал байлцуулна.
12	Бетон суурь	1 ком	Салхины хурд 50м/с, цасны тогтох зузаан 20см байхад тогтвортой бетон суурийг 2м тутамд М250 маркын бетон зуурмагаар хийнэ. Ус, чийгнээс хамгаалж, хар замаск түрхнэ. Нарны хавтангийн суурилуулалтын зургийг боловсруулж захиалагчтай зөвшилцөнө.

Хүснэгт 1.3 20 кВт чадалтай НЭХС-н (хосолмол нэг иж бүрдэл, бие даасан хоёр иж бүрдэл бүгд 3 иж бүрдэл) тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, жагсаалт:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Нарны хавтан	32	Нарны дэлгэц хавтан нийт чадал нь 20кВт, нэг бүр нь 650Вт чадалтай, моно кристалл. Системийн хүчдэл 1500В, АҮК 24%-аас дээш байна. Мөндөрийн туршилт 23м/с хурдтай 25мм-ийн мөндөр тэсвэрлэх туршилт хийсэн байна. Нүүрнээсээ 5400Па даралт тэсвэрлэхүйц бат бөх байна. Хамгаалалтын зэрэглэл нь IP68, Чадлын хүлцэл: 0...+3%; Нийцэх стандарт: IEC61730 Нарны дэлгэцний суурь, батерейны суурь, холболтын хайрцаг, хуваарилах самбар, холбох хэрэгслүүд гэх мэт тоноглолууд дагалдсан байна. Ажиллах хугацаа: 25 жил Үйлдвэрийн баталгаа: 10 жил

3	Хайбрид инвертер, 20кВт, 230/400В (Хосолмол НЭХС-ийн хувьд төвийн эрчим хүчний сүлжээнээс цахилгаан авах, нийлүүлэх шаардлага хангасан байх)	1	20кВт хүчин чадалтай 230/400В хүчдэл харгах, DC урвуу холболтын хамгаалалттай, гадна орчноос тусгаарлах IP66 байна. *Нарны дэлгэцний оролт:* Оролтын дээд чадал: 26 кВт Оролтын дээд хүчдэл: 1000 В MPPT Хүчдэлийн хүрээ: 150-850 В *Батерейны холболт:* Хүчдэлийн хүрээ: 160-700 В Цэнэглэх/ цэнэг алдуулах гүйдэл: 37 А Хяналт: Батарей хяналтай байна (BMS). Цэнэглэлтийн горим: лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан батерей байна. *Инвертерийн гаргалгаа:* Нэрлэсэн чадал: 20 кВт, Бүрэн чадал: 22 кВт, Хэлхээний гаргалтын гүйдэл: 29 А, Нэрлэсэн хүчдэл (V): 230/400, Фазын тоо: 3, Давтамж 50 Гц, Чадлын коэффицент 1 (-0.8–0.8) тохируулах боломжтой байна. Гүйдлийн THD (<3%) *Хамгаалалтууд:* DC урвуу холболтын хамгаалалттай, Хэт гүйдэл/хүчдлийн хамгаалалттай, Богино холболтын хамгаалалттай, Гүйдлийн алдагдлын хамгаалалттай, Сүлжээний хяналттай байна. Хамгаалалтын зэрэглэл IP 66 *Ерөнхий мэдээлэл:* Хийц: трансформаторгүй, агаарын хөргөлттэй, орчны чийгшил 0-100%, Ажиллах хэм: -40°C... +60 °C, Ажиллах өндөржилт (<4000м), Шуугианы үзүүлэлт (< 40 dB), Ачаалалгүй үеийн хэрэглээ (< 5 W), Мэдээлэл дамжуулалт, хяналт: LCD, LED, / WIFI / RS485/RS232/CAN, Вэб хяналтын систем Сүлжээний стандарт: IEC 61727, IEC 62116, CEI 0-21, EN 50549, NRS 097, RD 140, UNE 217002, OVE-Richtlinie R25, G99, VDE-AR-N 4105 Аюулгүй байдлын стандарт: IEC/EN 61000-6-1/2/3/4, IEC/EN 62109-1, IEC/EN 62109-2

3	Цэнэг хураагуур	1 ком	51.2V 100 Ац-ийн нэгж багтаамжтай 8 ширхэг, нийт 40.96 кВт.ц эрчим хүч хадгална. лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан. Ажиллах хэм: -0^0C - $+50^0$C, Нэгж батерейны хүчдэл: 51.2 В, Циклийн тоо: 6000, болон 15 жил Технологи: лити-ион (Lithium-ion) LFP, Стандарт: IEC62619, CE-EMC, UN 38.3
4	Цэнэг хураагуурын суурь	1 ком	Цэнэг хураагуур суурилуулах зориулалттай.
5	Нарны хавтангийн холболтын суурийн төмөр деталиуд	1 ком	Бетонд суурилуулах Т хэлбэрийн ган төмөр хөл, урд болон ард босоо хөлийн гар төмөр, Хөндлөн болон эгнээнд зориулсан ган төмөр зориулалтын төмөр деталиуд, залгааны деталиуд гэх мэт байна. Булан төмөр нь 5см х 5см өргөнтэй х 0.3см зузаантай байна. Дэлгэцийн тооноос хамаарсан, задгай талбайд суурилуулахаар үйлдвэрт хийгдсэн байна.
6	PV каблиуд	300м	Хар болон улаан өнгийн 4мм2 голчтой. Зэс голтой, өвөл хөлддөггүй.
7	DC кабель	60м	25мм2 голчтой, зэс утастай. Цэнэг хураагуураас инвертерт холбох
8	MC 4 коннектор	30ш	Нарны хавтангийн холболтод ашиглах
9	Газардуулга	1 ком	8ш зэс гадас, хооронд холбох 2см зузаантай полса
10	Аянга зайлуулагч	1 ком	2м өндөр шон, аянга зайлуулагч, 10м 6мм голчтой газардуулгын кабель Аянга зайлуулагчийг газарт зоож суурилуулахдаа хөндлөнгийн хяналт хийх нэг мэргэжилтнийг (хамгаалалтын захиргаанаас эсхүл төслөөс) заавал байлцуулна.
11	Бетон суурь	1 ком	Салхины хурд 50м/с, цасны тогтох зузаан 20см байхад тогтвортой бетон суурийг 2м тутамд М250 маркийн бетон зуурмагаар хийнэ. Ус, чийгээс хамгаалж, хар замаск түрхэнэ. Нарны хавтангийн суурилуулалтын зургийг боловсруулж захиалагчтай зөвшилцөнө.

Хүснэгт 1.4 35 кВт чадалтай НЭХС-н (хосолмол хоёр иж бүрдэл) тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, жагсаалт:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Нарны хавтан	54	Нарны дэлгэц хавтан: нийт чадал нь 35кВт, нэг нь 650Вт чадалтай, моно кристалл. Системийн хүчдэл 1500В, АҮК 24%-аас дээш байна. Мөндөрийн туршилт 23м/с хурдтай 25мм-ийн мөндөр тэсвэрлэх туршилт хийсэн байна. Нүүрнээсээ 5400Па даралт тэсвэрлэхүүц бат бөх байна. Хамгаалалтын зэрэглэл: IP68, Чадлын хүлцэл: 0...+3%, Нийцэх стандарт: IEC61730, Нарны дэлгэцний суурь, батерейны суурь, холболтын хайрцаг, хуваарилах самбар, холбох хэрэгслүүд гэх мэт тоноглолууд дагалдсан байна. Ажиллах хугацаа: 25 жил Үйлдвэрийн баталгаа: 10 жил
2	Хайбрид инвертер, 35кВт, 230/400В (Хосолмол НЭХС-ийн хувьд төвийн эрчим хүчний сүлжээнээс цахилгаан авах, нийлүүлэх шаардлага хангасан байх)	1	35кВт хүчин чадалтай 230/400В хүчдэл харгах, DC урвуу холболтын хамгаалалттай, гадна орчноос тусгаарлах IP66 байна. *Нарны дэлгэцийн оролт:* Оролтын дээд чадал: 45.5 кВт Оролтын дээд хүчдэл: 1000В MPPT Хүчдэлийн хүрээ: 150-850 В *Батерейны холболт:* Хүчдэлийн хүрээ: 160-800 В Цэнэглэх/ цэнэг алдуулах гүйдэл: 50 А Хяналт: Батарей хяналтай байна (BMS). Цэнэглэлтийн горим: лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан батарей байна. *Инвертерийн гаргалгаа:* Нэрлэсэн чадал: 35 кВт, Бүрэн чадал: 38.5 кВт, Хэлхээний гаргалтын гүйдэл: 50.8 А, Нэрлэсэн хүчдэл (V): 230/400, Фазын тоо: 3, Давтамж 50 Гц, Чадлын коэффициент 1 (-0.8–0.8) тохируулах боломжтой байна. Гүйдлийн THD (<3%) *Хамгаалалтууд:* DC урвуу холболтын хамгаалалттай, Хэт гүйдэл/хүчдэлийн хамгаалалттай,

			Богино холболтын хамгаалалттай, Гүйдлийн алдагдлын хамгаалалттай, Сүлжээний хяналттай байна. Хамгаалалтын зэрэглэл: IP 66 *Ерөнхий мэдээлэл:* Хийц: трансформаторгүй, агаарын хөргөлттэй, орчны чийгшил 0-100%, Ажиллах хэм: -40°C... +60°C, Ажиллах өндөржилт (<4000м), Шуугианы үзүүлэлт (< 40 dB), Ачаалалгүй үеийн хэрэглээ (< 5 W), Мэдээлэл дамжуулалт, хяналт: LCD, LED, / WIFI / RS485/RS232/CAN, Вэб хяналтын систем Сүлжээний стандарт: IEC 61727, IEC 62116, CEI 0-21, EN 50549, NRS 097, RD 140, UNE 217002, OVE-Richtlinie R25, G99, VDE-AR-N 4105 Аюулгүй байдлын стандарт: IEC/EN 61000-6-1/2/3/4, IEC/EN 62109-1, IEC/EN 62109-2
3	Цэнэг хураагуур	2 ком	51.2V 100 Ац-ийн нэгж багтаамжтай 8 ширхэг, нийт 40.96 кВт.ц-ийн 2 ком буюу 81.92кВт.ц эрчим хүч хадгална. лити-ион (Lithium-ion) төрлийн нарны эрчим хүчинд зориулсан. Ажиллах хэм: -0^0C - $+50^0$C, Нэгж батарейны хүчдэл: 51.2 В, Циклийн тоо: 6000, болон 15 жил Технологи: лити-ион (Lithium-ion) LFP, Стандарт: IEC62619, CE-EMC, UN 38.3
4	Цэнэг хураагуурын суурь	2 ком	Цэнэг хураагуур суурилуулах зориулалттай.
5	Нарны хавтангийн холболтын суурийн төмөр деталиуд	1 ком	Бетонд суурилуулах Т хэлбэрийн ган төмөр хөл, урд болон ард босоо хөлийн гар төмөр, Хөндлөн болон эгнээнд зориулсан ган төмөр зориулалтын төмөр деталиуд, залгааны деталиуд гэх мэт байна. Булан төмөр нь 5см х 5см өргөнтэй х 0.3см зузаантай байна. Дэлгэцийн тооноос хамаарсан, задгай талбайд суурилуулахаар үйлдвэрт хийгдсэн байна.
6	PV кабелиуд	300м	Хар болон улаан өнгийн 4мм2 голчтой. Зэс голтой, өвөл хөлддөггүй.
7	DC кабель	60м	25мм2 голчтой, зэс утастай. Цэнэг хураагуураас инвертерт холбох зориулалттай.
8	MC 4 коннектор	30ш	Нарны хавтангийн холболтод ашиглах

9	Газардуулга	1 ком	8ш зэс гадас, хооронд холбох 2см зузаантай полса
10	Аянга зайлуулагч	1 ком	2м өндөр шон, аянга зайлуулагч, 10м 6мм голчтой газардуулгын кабель, Аянга зайлуулагчийг газарт зоож суурилуулахдаа хөндлөнгийн хяналт хийх нэг мэргэжилтнийг (хамгаалалтын захиргаа эсвэл төслөөс) заавал байлцуулна.
11	Бетон суурь	1 ком	Салхины хурд 50м/с, цасны тогтох зузаан 20см байхад тогтвортой бетон суурийг 2м тутамд М250 маркийн бетон зуурмагаар хийнэ. Ус, чийгээс хамгаалж, хар замаск түрхэнэ. Нарны хавтангийн суурилуулалтын зургийг боловсруулж захиалагчтай зөвшилцөнө.

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------

АЖЛЫН ДААЛГАВРЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

“Тусгай хамгаалалттай газар нутгийн зарим хамгаалалтын захиргаанд алсын удирдлагатай камер болон нарны эрчим хүчний системээр хангах” тендерээр худалдан авах АЗХК-ын иж бүрдэлд орох тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, техникийн тодорхойлолт

Хүснэгт 2.1 АЗХК (**PTZ camera**)-ийн техникийн тодорхойлолт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	АЗХК / PTZ camera (хэвтээ/pan-360^0, босоо/tilt чиглэлээр тасралтгүй бичдэг, татдаг/zoom камер)	6 ширхэг	*Хамгийн багадаа доорх үзүүлэлтийг хангасан байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:* - Үндсэн видео урсгал нь 8MP өндөр нягтралтай, Main stream нь 3840x2160 -тай байх, 25-30fps чадвартай байна. - Гурван төрлийн видео урсгалыг дэмждэг байна. Үүнд: Main stream, Sub-stream, Third stream - Дүрс нягтруулгын технологи нь H.265+/H.265 болон түүнээс дээш байна. - Дүрс дамжуулалтын хурд/Video Bit Rate: 128Kbps ～16384Kbps - 10 хүртэл өөр текст/тэмдэглэл зэрэг харуулдаг байх/(Up to 10 OSDs) - Автомат (IR-cut filter with auto switch (ICR)) өдөр, шөнийн горимтой байх. - 40x -ээс доошгүй оптик таталттай байна. - 16x эсвэл түүнээс дээш дижитал таталттай байна. - Камерын хөдөлгөөнийг удирдах механизм нь камерын байрлал, чиглэл, эргэлтийн өнцөг, фокус зэргийг лазер мэдрэгчийн тусламжтайгаар маш нарийн хэмжиж, сүлжээгээр хянах зориулалттай Laser Network Positioning System байна. - Хяналтын камер нь шонгийн дээд хэсэгт, шонгийн бүтцийн элементүүдийн халхлалт үүсгэхгүй байхаар суурилагдана. Камерын харах өнцөг (Field of View) нь шон болон дагалдах тоноглолуудаар саатуулагдахгүй байх ёстой. - Ухаалаг функцүүдээр тоноглогдсон байх. Үүнд: Олон биетийг илрүүлэх/Multi-target Detection-тэй Хуурамч дуудлагыг багасгах зорилгоор хүнболон машиныг ялгаж таних (Human and Vehicle classifi cation). Тохируулсан хил хязгаарыг давах үеийг илрүүлэх

			(Cross line detection). Тохируулсан талбай руу нэвтрэх эсвэл гарах үеийг илрүүлэх (Intrusion area detection) Хяналтын камерыг гадны үйлчлэлээр хөдөлгөх, оролдох гэх мэтийг илрүүлэх (Video tampering alarm) Ухаалаг хөдөлгөөн мэдрэгч функц (Next generation motion detect). Бусад ухаалаг функцүүд (network disconnected, IP address conflict, illegal login, HDD full, HDD error). - Манантай үед дүрсийг тогтворжуулах функцтэй байна (Optical defog). - DORI: (Detect)/(Илрүүлэх) хүнийг ~4,8 км, машиныг ~10 км-ээс доошгүй зайд илрүүлэх боломжтой байх, Observe/(ажиглах зай) 62.2 м – 1,931.8 м, Recognize/(таних зай) 31.1 м - 965.9 м, Identify/(тодорхойлох зай) 15.5 м - 482.9 м. - Камер нь шонгийн доргилт, салхи болон орчны механик чичиргээнээс үүдэлтэй дүрсний тогтворгүй байдлыг бууруулах зориулалттай оптик дүрс тогтворжуулагч (OIS – Optical Image Stabilization) функцтэй байна. - Маш бага гэрлийн орчинд сайн дүрслэл үзүүлэх дэвшилтэд технологитой байна (Color: 0.0005 Lux @ (F1.6, AGC ON), B/W: 0.0001 Lux @ (F1.6, AGC ON), 0 lux with IR). - Камераас цацруулах нэмэлт IR гэрэлтүүлэг нь 1000м хүртэлх зайнд ажилладаг буюу лазер үүсгүүртэй байна. Уг гэрэлтүүлгийн функц нь хол, ойрын зайнаас хамаарч ухаалгаар тохирч ажилладаг байна. (Smart IR, up to 1000m) - Камер нь линзний гадаргууг цэвэрлэх зориулалтын автомат арчих (wiper) төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Төхөөрөмж нь хур тунадас болон бороог илрүүлэх мэдрэгчтэй (rain sensor) байх ба илрүүлэлтийн дагуу линзийг автоматаар цэвэрлэдэг байна. Мөн операторын зааврааар гар аргаар удирдан ажиллуулах боломжтой байна. - Камер нь өөрт тохирсон үйлдвэрлэлийн зориулалттай AC220V → DC тэжээлийн хувиргагч блок (power supply unit)-оор хангагдана. Тэжээлийн блок богино залгааны болон хэт хүчдэлийн хамгаалалттай, аянгын хамгаалалттай байх бөгөөд тасралтгүй ажиллагааг хангах

